ЗАВХАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Идэр сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ЗАА-2022/131/СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улиастай хот<br>2022 он | Дарга, Тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа<br>Утас: 70463612 Цахим хаяг: batundraa@audit.gov.mn<br>Ахлах аудитор : Б.Дагвасүрэн<br>Утас:99014227 Цахим хаяг:dagvasurenb@audit.gov.mn<br>Аудитор П.Ганцолмон<br>Утас:70157405 Цахим хаяг:uliastaivanaudit@ubaudit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**


1. **Аудитын санал дүгнэлт** ........ 2

2. **Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 4

 2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан ........ 5

 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 7

 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 8

 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 10

3. **Аудитын тайлан**

 3.1 Ерөнхий зүйл ........ 12

 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 12

 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 12

 3.4 Материаллаг байдал ........ 13

 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 13

 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 14

 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 14

 3.8 Аудитын гол асуудал ........ 14

 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал, Шилэн дансны хуулийн хэрэгжилт, бусад хууль тогтоомж ........ 14

 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 15

 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 15

4. **Аудитын илрүүлэлт** ........ 15


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1. Төрийн аудитын санал, дүгнэлт

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

2022.02.24 № 1302/362

танай ________ -ны № ________ -т

ИДЭР СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ С.АМАРЖАРГАЛ-Д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Идэр сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Идэр сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **53,210,934.84** | **64,023,592.84** |
| **33** | **АВЛАГА** | 568,750.00 | 568,750.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 281,400.00 | 281,400.00 |
| **335** | **Бусад авлага** | 287,350.00 | 287,350.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 257,350.00 | 257,350.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 30,000.00 | 30,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 52,642,184.84 | 63,454,842.84 |
| **351** | **Түүхий эд материал** | 1,723,490.00 | 2,930,390.00 |
| 35130 | Эм боох материал | 1,723,490.00 | 2,930,390.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 50,918,694.84 | 60,524,452.84 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 187,600.00 | 150,600.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 14,422,900.00 | 16,862,300.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 485,700.00 | - |
| 35460 | Хүнсний материал | 24,147,915.00 | 25,768,243.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 11,674,579.84 | 17,743,309.84 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **343,091,285.15** | **337,544,649.76** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 343,091,285.15 | 337,544,649.76 |
| **392** | **Биет хөрөнгө** | 331,641,285.15 | 326,507,149.76 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 326,885,880.00 | 326,885,880.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (20,430,367.44) | (30,645,551.16) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 52,686,028.00 | 61,538,928.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (38,938,983.04) | (40,279,285.84) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 39,797,073.00 | 39,797,073.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (30,505,639.12) | (32,937,187.99) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 4,720,000.00 | 4,720,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (4,720,000.00) | (4,720,000.00) |
| 39217 | Ном | 2,147,293.75 | 2,147,293.75 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 11,450,000.00 | 11,037,500.00 |
| 39301 | Програм хангамж | 1,650,000.00 | 1,650,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | - | (412,500.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 9,800,000.00 | 9,800,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **396,302,219.99** | **401,568,242.60** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **396,302,219.99** | **401,568,242.60** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 396,302,219.99 | 401,568,242.60 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 29,649,692.05 | 29,649,692.05 |
| 51101 | Өмч: - төрийн | 29,649,692.05 | 29,649,692.05 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 365,946,913.37 | 371,212,935.98 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 365,946,913.37 | 365,946,913.37 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 5,266,022.61 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 705,614.57 | 705,614.57 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **396,302,219.99** | **401,568,242.60** |

## 2.2 Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **277,596,800.00** | **289,728,430.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **239,783,300.00** | **252,496,530.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,499,000.00 | 4,889,230.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,499,000.00 | 4,889,230.00 |
| 1E+06 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 3,499,000.00 | 4,889,230.00 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 236,284,300.00 | 247,607,300.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 236,284,300.00 | 247,607,300.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **37,813,500.00** | **37,231,900.00** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 37,813,500.00 | 37,231,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт | 37,813,500.00 | 37,231,900.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **275,146,785.88** | **284,462,407.39** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **275,146,785.88** | **284,462,407.39** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 261,388,387.52 | 263,770,178.39 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 167,438,634.64 | 169,083,534.00 |
| 210101 | Үндсэн цалин | 116,152,275.00 | 122,827,166.00 |
| 210102 | Нэмэгдэл | 36,927,075.64 | 33,014,324.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 500,000.00 | 750,000.00 |
| 210104 | Урамшуулал | 13,859,284.00 | 12,492,044.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | - |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТЭҮГ/ | - | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 20,617,847.00 | 22,000,741.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,154,355.00 | 15,491,829.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,674,385.00 | 1,716,035.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,339,507.00 | 1,366,110.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 313,800.00 | 305,750.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,135,800.00 | 3,121,017.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 34,910,990.00 | 36,157,866.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,805,515.00 | 1,508,906.00 |
| 210302 | Түлш, халаалт | 32,205,275.00 | 34,298,960.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 900,200.00 | 350,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,967,550.00 | 4,168,580.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,077,250.00 | 1,242,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 836,500.00 | 836,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 610,000.00 | 590,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 90,400.00 | 90,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,353,400.00 | 1,409,280.00 |
| **2105** | **Норматив зардал** | 17,752,130.00 | 13,955,222.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 848,010.00 | 1,364,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 16,000,020.00 | 11,686,322.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 904,100.00 | 904,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 320,000.00 | 1,291,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 320,000.00 | 1,291,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 265,000.00 | 336,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 265,000.00 | 336,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 911,000.00 | 540,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр | 812,000.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 540,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 99,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 14,205,235.88 | 16,236,835.39 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 887,750.00 | 1,837,300.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 13,317,485.88 | 14,399,535.39 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 13,758,398.36 | 20,692,229.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 13,758,398.36 | 20,692,229.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **2,450,014.12** | **5,266,022.61** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 3,563,572.00 | - |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 3,563,572.00 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (3,563,572.00) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(1,113,557.88)** | **5,266,022.61** |

## 2.3 Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **29,649,692.05** | **705,614.57** | **365,946,913.37** | **396,302,219.99** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **29,649,692.05** | **705,614.57** | **365,946,913.37** | **396,302,219.99** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | - | - |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **29,649,692.05** | **705,614.57** | **365,946,913.37** | **396,302,219.99** |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **29,649,692.05** | **705,614.57** | **365,946,913.37** | **396,302,219.99** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **29,649,692.05** | **705,614.57** | **365,946,913.37** | **396,302,219.99** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 5,266,022.61 | **5,266,022.61** |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **29,649,692.05** | **705,614.57** | **371,212,935.98** | **401,568,242.60** |

## 2.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **274,097,800.00** | **284,839,200.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **236,284,300.00** | **247,607,300.00** |
| 123 | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 236,284,300.00 | 247,607,300.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 236,284,300.00 | 247,607,300.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **37,813,500.00** | **37,231,900.00** |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 37,813,500.00 | 37,231,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт | 37,813,500.00 | 37,231,900.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **272,447,800.00** | **275,986,300.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **272,447,800.00** | **275,986,300.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **258,689,401.64** | **255,294,071.00** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 166,697,889.64 | 169,083,534.00 |
| 210101 | Үндсэн цалин | 108,494,067.09 | 123,315,636.00 |
| 210102 | Нэмэгдэл | 40,149,712.55 | 32,525,854.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,809,737.00 | 750,000.00 |
| 210104 | Урамшуулал | 9,244,373.00 | 12,492,044.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 21,358,592.00 | 22,000,741.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,895,100.00 | 15,491,829.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,674,385.00 | 1,716,035.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,339,507.00 | 1,366,110.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 313,800.00 | 305,750.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,135,800.00 | 3,121,017.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 35,210,990.00 | 36,337,866.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,805,515.00 | 1,508,906.00 |
| 210302 | Түлш, халаалт | 32,235,275.00 | 34,298,960.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,170,200.00 | 530,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 6,417,200.00 | 6,390,980.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,205,400.00 | 1,205,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 836,500.00 | 836,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 700,000.00 | 590,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 90,400.00 | 90,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,584,900.00 | 3,668,680.00 |
| 2105 | **Норматив зардал** | 24,112,130.00 | 16,782,450.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,571,500.00 | 2,571,700.00 |
| 210502 | Хоол, хүнс | 20,636,530.00 | 13,306,650.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 904,100.00 | 904,100.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 805,700.00 | 805,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 805,700.00 | 805,700.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 265,000.00 | 336,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 265,000.00 | 336,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 911,000.00 | 540,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 812,000.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 540,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 99,000.00 | - |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,910,900.00 | 3,016,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,910,900.00 | 3,016,800.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **13,758,398.36** | **20,692,229.00** |
| 2133 | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 13,758,398.36 | 20,692,229.00 |
| 213303 | Төлөвлөх шилжүүлэг | 13,758,398.36 | 20,692,229.00 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **1,650,000.00** | **8,852,900.00** |
| 5 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **1,650,000.00** | **8,852,900.00** |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,650,000.00** | **8,852,900.00** |
| 2200 | **Дотоод эх үүсвэрээр** | 1,650,000.00 | 8,852,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,650,000.00 | 8,852,900.00 |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(1,650,000.00)** | **(8,852,900.00)** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 294,017,300.00 | 284,839,200.00 | 9,178,100.00 | 97% |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 294,017,300.00 | 284,839,200.00 | 9,178,100.00 | 97% |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 294,017,300.00 | 264,146,971.00 | 29,870,329.00 | 90% |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 176,238,200.00 | 169,083,534.00 | 7,154,666.00 | 96% |
| 210101 | Үндсэн цалин | 116,238,100.00 | 123,315,636.00 | (7,077,536.00) | 106% |
| 210102 | Нэмэгдэл | 47,111,600.00 | 32,525,854.00 | 14,585,746.00 | 69% |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 500,000.00 | 750,000.00 | (250,000.00) | 150% |
| 210104 | Урамшуулал | 12,388,500.00 | 12,492,044.00 | (103,544.00) | 101% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 23,792,200.00 | 22,000,741.00 | 1,791,459.00 | 92% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,742,600.00 | 15,491,829.00 | 1,250,771.00 | 93% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,762,400.00 | 1,716,035.00 | 46,365.00 | 97% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,409,900.00 | 1,366,110.00 | 43,790.00 | 97% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 352,500.00 | 305,750.00 | 46,750.00 | 87% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,524,800.00 | 3,121,017.00 | 403,783.00 | 89% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 39,226,200.00 | 36,337,866.00 | 2,888,334.00 | 93% |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,200,000.00 | 1,508,906.00 | 1,691,094.00 | 47% |
| 210302 | Түлш, халаалт | 35,498,900.00 | 34,298,960.00 | 1,199,940.00 | 97% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 527,300.00 | 530,000.00 | (2,700.00) | 101% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,417,200.00 | 6,390,980.00 | 26,220.00 | 100% |
| 210401 | Бичиг хэрэг | 1,205,400.00 | 1,205,400.00 | - | 100% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 836,500.00 | 836,500.00 | - | 100% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 700,000.00 | 590,000.00 | 110,000.00 | 84% |
| 210404 | Ном, хэвлэл | 90,400.00 | 90,400.00 | - | 100% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,584,900.00 | 3,668,680.00 | (83,780.00) | 102% |
| **2105** | **Нормативт зардал** | 33,457,100.00 | 16,782,450.00 | 16,674,650.00 | 50% |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,571,700.00 | 2,571,700.00 | - | 100% |
| 210502 | Хоол, хүнс | 29,981,300.00 | 13,306,650.00 | 16,674,650.00 | 44% |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 904,100.00 | 904,100.00 | - | 100% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 805,700.00 | 805,700.00 | - | 100% |
| 210604 | Урсгал засвар | 805,700.00 | 805,700.00 | - | 100% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,356,100.00 | 336,000.00 | 1,020,100.00 | 25% |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,356,100.00 | 336,000.00 | 1,020,100.00 | 25% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 813,700.00 | 540,000.00 | 273,700.00 | 66% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 813,700.00 | 540,000.00 | 273,700.00 | 66% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11,910,900.00 | 11,869,700.00 | 41,200.00 | 100% |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,910,900.00 | 11,869,700.00 | 41,200.00 | 100% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 20,692,229.00 | (20,692,229.00) | |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | 20,692,229.00 | (20,692,229.00) | |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | 20,692,229.00 | (20,692,229.00) | |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 294,017,300.00 | 284,839,200.00 | 9,178,100.00 | 97% |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 253,985,400.00 | 247,607,300.00 | 6,378,100.00 | 97% |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 253,985,400.00 | 247,607,300.00 | 6,378,100.00 | 97% |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 40,031,900.00 | 37,231,900.00 | 2,800,000.00 | 93% |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 40,031,900.00 | 37,231,900.00 | 2,800,000.00 | 93% |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Завхан аймгийн Идэр сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллага Завхан аймгийн Идэр сумын цэцэрлэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Улиастай ван аудит ХХК-ийн ахлах аудитор П.Ганцолмон, аудитор Д.Гэрэлхүү нар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Идэр сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 20-ны өдрийн 02/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Идэр сумын цэцэрлэг нь хүүхэд бүрийн сурах үйлийг дэмжиж, сургуулийн өмнөх боловсролын эзэмшүүлж хоцрогдолгүй сургах,багшийн хөгжлийг хангах боломжийг бүрдүүлж, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлж, хосолсон сургалтын орчныг бүрдүүлж ажиллах зорилготой Сумын Засаг даргын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Идэр сумын цэцэрлэг нь Дотоод аудитын нэгж байхгүй.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Идэр сумын цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

**3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 289,728,4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,897,2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 70 хувиар буюу 2,028,09 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Авлага | 568.7 | 568.7 | - |
| Бараа | 52,642.1 | 63,454.8 | 10,812.7 |
| Үндсэн хөрөнгө | 343,091.2 | 337,544.6 | -5,546.6 |
| **Нийт хөрөнгө** | **396,302.0** | **401,568.1** | **5,266.1** |
| Өр төлбөр | | | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 396,302.0 | 401,568.1 | 5,266.1 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө** | **396,302.0** | **401,568.1** | **5,266.1** |

Авлага дансны үлдэгдлийг тайлант онд барагдуулаагүй бөгөөд энэ нь ажиллагчидтай холбогдсон авлага, байгууллагаас авах авлагууд байна..

Бараа материалын дансны үлдэгдэл 10,812.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 26,196.0 мянган төгрөг, хандиваар 4,889.2 мянган төгрөгөөр тус тус бэлтгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,546.6 мянган төгрөгөөр буурсан нь элэгдэлийн зардалтай холбоотой. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 8,852.9 мянган төгрөгөөр хөрөнгө бэлтгэсэн.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,226.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 294,017.3 мянган тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн санхүүжилтаас 37,231.9 мянган төгрөг, улсын төсөвөөс 247,607.3 мянган төгрөг нийт 284,839.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 264,147.0 мянган төгрөгийг зарцуулж, 20,692.2 мянган  төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт орлого бүрдүүлээгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын  2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 146 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба 6 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжиийн холбогдох заалттай нийцсэн байна   гэж дүгнэлээ.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлага өгөгдөөгүй байна.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 568.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 568.0 мянган төгрөгийн алдаанд албан шаардлага хүргүүллээ. Аудитын явцад залруулсан алдаа байхгүй.

**4.1 Залруулсан алдаагүй**

**4.2 Төлбөрийн акт хүргэгдээгүй.**

**4.3 Албан шаардлага:** Өмнөх оны авлагын үлдэгдэл 568.0 мянган төгрөгт албан шаардлага хүргүүлсэн болно.

**4.4 Зөвлөмж**

Аудитаар илэрсэн 568.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 шаардлага өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

- ✓ Илрүүлэлт: Тус цэцэрлэг нь тайлант хугацаанд 2020 оны эцсийн санхүүгийн тайлангаар 568.0 мянган төгрөгийн авлагатай байсан нь 2021 онд барагдуулаагүй байгааг тайланд тусгасан байна.

- ✓ Өгсөн зөвлөмж: Авлага барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн хууль тогтоомжинд нийцэхгүй байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 3 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Идэр сумын цэцэрлэг | 1 | 0.6 | - | - | - | - | 1 | 0.6 | - | - |